

**ХЯТАДЫН КОММУНИСТ НАМЫН  
VIII ИХ ХУРЛЫН ТУХАЙ**  
(25 жилийн ойд нь)

**Ч. Бямбаа**

1958 оны намар Хятадын Коммунист Намын VIII их хурал хуралдаж, хятадад нийгэм-улс төр, эдийн засаг, соёлын гүн гүнзгий өөрчлөлт хийх, түүхэн ахар богино хугацаанд социализм байгуулах зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэ нь хятадын ард түмнээр барахгүй юуны өмнө Азийн ард түмний энх тайван, ардчилал, социализм, нийгмийн дэвшилтэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм. Иймээс марксист түүх бичлэгт ХКН-ын VIII их хурлын үндэсний ба олон улсын ач холбогдлыг өндөр үнэлж ирсэн. Хятадын ард түмний жинхэнэ анд нөхөд, Хятадын социалист ирээдүйг эрхэмлэн хүндэтгэгч хүн бүхэн өнөөдөр ч гэсэн ХКН-ын VIII их хурлын түүхт шийдвэрийг ямагт дэмжин, сайн сайхнаар дурсан тэмдэглэж байна.

ХКН-ын VIII их хурал, хятадын жинхэнэ марксист-ленинист коммунистууд, ажилчин, хөдөлмөрчин ард түмний оюун санаанд хэзээ ч мартагдахгүй түүхэн ач холбогдолтой хэд хэдэн чухал заалт гаргасан билээ. Тэдгээр нь:

**Нэгдүгээрт**, Хятадын хувьсгалын дараахи нийгмийн өөрчлөлт нь социализм, капитализм хоёрын хоорондын «хэн нь хэнийгээ» гэдэг тэмцэл ид өрнөж байсан нөхцөлд хот, хөдөөд социалист өөрчлөлтийг аажмаар хийж, БНХАУ-д социализмын үндсийг байгуулах шилжилтийн үеийн зорилтыг юуны өмнө хөдөө аж ахуй, хувийн худалдаа болон капиталист үйлдвэрлэлийг социалист ёсоор өөрчлөн, социалист аж үйлдвэржүүлэлтийг алхам алхмаар хэрэгжүүлэхэд чиглэгдсэн;

**Хоёрдугаарт**, Нийгмийн өөрчлөлтөнд ажилчин анги, нийт хөдөлмөрчин олон түмний хөдөлмөрийн идэвхийг байнга өрнүүлэн, тэдний аж амьдрал соёлын түвшинг ямагт дээшлүүлж, хийсний хирээр хуваарилах социалист зарчмыг гуйвалтгүй биелүүлэх; түүний материаллаг ба соёлын үндэс болсон улс ардын аж ахуй, соёлыг 1958-1962 онд хөгжүүлэх II таван жилийн төлөвлөгөөг баталсан юм;

**Гуравдугаарт**, ХКН-ын дотоод амьдралд зарчмын чухал ач холбогдолтой онол, үзэл суртал, улс төрийн шинэ заалтыг намын дүрэмд оруулан: «Намын бүхий л үйл ажиллагааны онолын үндэс бол марксизм-ленинизм мөн. Гагцхүү марксизм-ленинизм л нийгмийн хөгжлийн бодит зүй тогтлыг зөвөөр тайлбарлаж, социализм, коммунизм байгуулах замыг, зөв заана»<sup>1</sup> гэж тунхагласан юм. Энэ заалт бол 1945 онд хуралдсан ХКН-ын VII их хурлаас намын дүрэмд оруулсан «Мао Зэдуны үзэл санааг удирдлага болгоно» гэсэн марксизм-ленинизмд харш заалтыг өөрчилсөн туйлын чухал ач холбогдол бүхий зүйл мөн.

**Дөрөвдүгээрт**, Гадаад бодлогын үндсэн чиглэлийг тэмдэглэхдээ: «ЗХУ, социалист бусад оронтой тогтоосон Хятадын найрамдал, нэгдэл мөнх бөгөөд эвдэршгүй юм. Энэ нэгдэл, нягтралыг цаашид хөгжүүлэн

<sup>1</sup>Дундад улсын Эв Хамт Намын Дүрэм. Бээжин, 1956, 5 дугаар тал, (монголоор)

бэхжүүлэх нь бидний хувьд хамгийн эрхэм интернационалч үүрэг, манай орны гадаад бодлогын үндэс мөн»<sup>2</sup> гэсэн билээ. Тус их хурлаас эдгээр түүхэн заалтыг гаргахад нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл бол ЗХУ ба социалист бусад орноос БНХАУ байгуулагдсаны дараахи ахар богино хугацаанд хятадын ард түмэнд үзүүлсэн эдийн засаг, шинжлэх ухаан-техник болон соёлын асар их тусламж, байнгын нөхөрсөг хамтын ажиллагаа байв. Энэ нь цаашид хятадад социализм байгуулах ХКН-ын жанжин шугамыг хэрэгжүүлэх бат бааз суурь болох ёстой байв. Тийм ч учраас түүнийг тус намын их хуралд оролцсон олон улсын коммунист, ажилчны 50 гаруй намын төлөөлөгчид, хятадын жинхэнэ интернационалч коммунистууд, ажилчид, дэвшилт нам бүлгүүдийн төлөөлөгчид хэлсэн үгэндээ өндөр үнэлэн талархаж байлаа.

Хятадын хөдөлмөрчин ард түмэн тэр үед, удаан жилийн дотоодын самуун, дэлхийн дайны хөлд доройтсон аж ахуй, соёлоо ЗХУ ба социалист бусад орны тусламжтайгаар түргэн сэргээн босгох нөр их хөдөлмөрийг өрнүүлэн, анхдугаар таван жилийнхээ төлөвлөгөөт зорилтыг амжилттай биелүүлж ХКН-ын VIII их хурлаас дэвшүүлсэн социализм байгуулах түүхэн шийдвэрийг баяртай хүлээн авч, зориг бадрангуй хөдөлмөрлөж байв.

Гэвч хятадын нийгмийн удирдах хүч болж байсан ХКН-ын удирдлагын дотор пролетарийн интернационалч ба жижиг хөрөнгөтний үндсэрхэх их гүрний дээрэнгүй үзэлтэн нарын хооронд явагдаж байсан хурц тэмцлээс хятад дахь социализмын хувь заяа үлэмжийн их хүнд бэрхшээлтэй тулгарсан юм. Хятадын нийгмийн суурь давхаргын түүхэн өвөрмөц онцлогтой нягт холбоотой эсрэг тэсрэг тэр хоёр хүчний удаан жилээр уламжлагдсан ширүүн тэмцэл ХКН-ын VIII их хурлыг бэлтгэж байхад ч янз бүрийн хэлбэрээр зогсолтгүй үргэлжлэж байсан ба цаашид ч улам даамжирсан юм.

ХКН-ын VIII их хурлын дараа хагас жил болоогүй байхад Мао Зэдун түүний бүлгийнхний санаачлагаар эхэлсэн «ажлын арга барилыг засч залруулах», «баруунтныг» эсэргүүцэх хөдөлгөөн зэрэг нь мөн чанараараа ХКН -ын доторхи интернационалч хүчний эсрэг чиглэсэн ажиллагаа байв. Мао Зэдун түүний бүлгийнхэн ХКН-ын Төв Хорооны удирдлагад эзэлж байсан байр сууриа ашиглан 1957-1958 онуудад ХКН-ын VIII их хурлын шийдвэрийг засварлахаар хаалттай өдий төдий зөвлөлгөөн хийсний дараа, түүнийгээ нам төрийн бодлого болгон шууд зарлан 1958 оны тавдугаар сард хуралдсан ХКН-ын VIII их хурлын II чуулганаас эдийн засгийг «үсрэнгүй» давшилтаар хөгжүүлэх тухай шийдвэр гаргав. Тэр шийдвэрийн онолын үндэслэл бол 1956 оны дөрөвдүгээр сарын 25-нд Төв Хорооны Улс Төрийн Товчооны өргөтгөсөн хуралдаан дээр Мао Зедуны хэлсэн «Арван их харилцааны тухай»<sup>\*</sup> гэдэг үг байжээ. Маогийнхны улс төрийн бодлогын тэр чиг шугам цаашид даамжирсаар «Социализмыг арвин хурдан, сайн, хэмнэлттэй байгуулах» гэдэг лоозонгоор гоёж чимэглэн «жанжин шугам», «их үсрэлт», «ардын коммун» гэсэн адал балмад «гурван улаан туг»-ийн бодлогыг тунхагласан билээ. Маогийнхны «их үсрэлтийн» бодлогын мөн чанар нь тэдний үндсэрхэх жанжлах үзэл эрмэлзлэлийн илрэл байв. Иймээс ч тэд өөрсдийнхөө алдаатай шугамыг социалист бусад орон болон дэлхийн коммунист хө-

<sup>2</sup>Дундад УлсынЭв Хамт Намын Төв Хорооноос, намын бүх улсын төлөөлөгчдийн наймдугаар их хуралд тавьсан улс төрийн илтгэл. Бээжин., 1956. 152 дугаар талд. (монголоор)

\*Мао Зэдун, социализм байгуулах, асуудлаар ЗХУ-ын туршлагыг ул хэрэгссэн учир, тухайн үед хэвлэгдэхгүй байсаар байгаад, анх 1977 онд «Улаан туг» сэтгүүлийн № 1 дараа нь Мао Зедуны сонгомол зохиолын V ботид тус тус бүрэн эхээрээ нийтлэгдсэн.

дөлгөөнд тулган хүлээлгэхийг бүх хүчээрээ оролдсон билээ. Маогийнхны «их үсрэлтийн» чиг шугам зөвхөн эдийн засгаар барахгүй, хятадын үзэл суртал, шинжлэх ухаан, гэгээрэл, урлаг, утга зохиолд ч ихээхэн нөлөөлөх болсон. Чухам энэ үеэс Маогийнхан ХКН-ыг ЗХУКН ба социалист хамтын нөхөрлөлийн орнууд, дэлхийн коммунист хөдөлгөөнөөс хөндийрүүлэн тусгаарлаж, тэдгээрийн эсрэг өөрсдийнхөө «онцгой чиг шугам» гэгчийг гарган тавьж, «Мао Зэдуны үзэл санааг» марксизм-ленинизмийн хөгжлийн «шинэ дээд шат» мэтээр сурталчлах болсон юм. «Их үсрэлтийн» бодлогоор маогийнхны тооцоолсон хүнд үйлдвэрийн талаар ойрын хугацаанд Английг гүйцэж түрүүлэх зорилт, аж үйлдвэрт хэрэглэсэн «бага металлургийн» арга, хөдөө тосгоныг бүхэлд нь хамарсан «Ардын коммун» зэргийн аль нь ч амжилтанд хүрч чадаагүй юм.

ХКН-ын VIII их хурлын шийдвэрт эрс харшилсан «Их үсрэлтийн» бодлого БНХАУ-ын эдийн засаг, нийгмийн амьдралын тэнцвэрийг ноцтой алдагдуулан, социалист бүтээн байгуулалтад ихээхэн хор хохирол учруулсныг 1959 оны наймдугаар сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны VIII бүгд хурал дээр Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн Пэн Дэхуай, улс төрийн товчооны орлогч гишүүн Жан Вэньтянь нар болон мужийн намын хороод, яам, албан газруудын удирдах олон коммунист буруушаан шүүмжилсэн билээ. Тус бүгд хурал, 1958 оны Хятадын улс ардын аж ахуйн хөгжилтийн дүн үзүүлэлт тоо баримтууд худлаа болохыг илчлэн залруулж мэдээлээд, 1959 оны төлөвлөгөөний үзүүлэлтийн тоог бууруулан засах, мөн «Ардын коммун»-д өөрөөр хандан, хөдөлмөрлөснөөр нь хувиарлах, аж ахуйн тооцооны зарчмыг амьдралд шат дараатай нэвтрүүлэх социалист зарчимд эргэж орох зэргийг санал болгосон юм. ХКН-ын Төв Хорооноос энэ заалтын дагуу тухайн үед авч явуулсан зарим арга хэмжээний үр дүнд 1962 оны эцсээр БНХАУ-ын эдийн засгийн байдал зарим талаар тогтворжих байдалтай болсон билээ.

Гэвч Маогийн бүлгийнхэн VIII бүгд хурлын шийдвэрийн дагуу улс төрийн бодлогынхоо үндсэн чиг шугамыг зарчимчаар өөрчлөөгүйгээр барахгүй, «их үсрэлтийн» бодлого балран унасан алдаагаа хятадын ард түмнээс нуун далдалж зөвлөлтийн эсрэг үндсэрхэх үзлээ улам дэгдээхэд овжин ашиглаж, «өөрийн хүчинд тулгуурлах», «хуучин арга барилыг хятадын нөхцөлд хэрэглэх албагүй» гэх мэтээр сурталчилах болсон юм.

Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг маогийнхны үзлийн цаашдын гүнзгийрэлт нь ХКН-ын эрүүл саруул жинхэнэ марксист ленинист коммунистууд ба ажилчин анги, нийгмийн бусад дэвшилт үзэлтнүүд болон олон улсын коммунист хөдөлгөөний ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан билээ. Мао Зэдун түүний бүлгийнхэн энэ хямралаас гарч ХКН, төрийн эрх мэдлээ байнга эзэгнэн суух байраа алдахгүйн тулд адал балмад улс төрийн кампаньт ажил «Соёлын хувьсгал» гэгчийг хийх болсон юм. 1966 оны тавдугаар сараас 1976 оны аравдугаар сар хүртэл үргэлжилсэн «соёлын хувьсгал» нь ХКН, БНХАУ-ын хөгжилд нөхөж баршгүй их сүйрэл учруулснаар зогсоогүй хятадын ард түмний нэрийг дэлхий дахинд гутаасан билээ. Түүгээр хятад оронд учирсан зарим хохирлын тухай гадаадын хэвлэлд бичихдээ: «соёлын хувьсгал» гэгчийн үеэр 5 сая коммунистууд залхаан цээрлүүлгэд өртөгдөж, 400 мянган хүн алагдаж, 1966-1969 оны хооронд 100 сая хүн улс төрийн мөрдлөг хавчилгын золиос болсон юм»<sup>3</sup> гэж тэмдэглэжээ. 1976 оны есдүгээр сард Мао Зэдуныг үхсэнээс хойш түүний залгамжлагчид «соёлын хувьсгал»-ын хор

<sup>3</sup>«Акахата», 1976, VI. 15

уршгийг арилган, маоизмын харгис ман чанарыг цагаатгаж, засварлан «шинэчлэх» гэж зүсэн бүрээр оролдож байна.

Гэвч хятадын одоогийн эрх баригчид мөн л зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг үндсэрхэх, их гүрний дээрэнгүй үзэлдээ автагдан, империализм, олон улсын харгис хүчнүүдтэй бүх талаар эвсэн сүлбэлдэж Мао Зэдунгүйгээр маоизмыг үргэлжлүүлж байгаа учир хятадын нийгэм, эдийн засаг, улс төр, үзэл суртал гүн гүнзгий хямралд байнга уяатай хэвээрээ байна. Хятадын эрх баригчид 1981 оны зургадугаар сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны VI бүгд хурлаас баталсан «БНХАУ байгуулагдсанаас хойших ХКН-ын түүхийн асуудлуудын тухай шийдвэр» гэсэн 8 хэсэг 38 зүйлтэй том баримт бичигт ХКН-ын VIII их хурлыг «амжилттай хурал болсон»<sup>4</sup> гэж цөөн үгээр дурдсан боловч ХКН-аас ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой найрамдалт харилцаа, бүх талын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх тухай ХКН-ын VIII их хурлаас өгсөн заалтын тухай өчүүхэн ч дурдалгүй өнгөрчээ. 1981 оны долдугаар сарын 1-нд ХКН байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэсэн баярын хурал дээр ХКН-ын Төв Хорооны дарга Ху Яобаны хэлсэн үгэнд ХКН-ын VIII их хурлын тухай ганц ч үг ороогүй байна. Энэ бүхэн нь ХКН-ын одоогийн удирдлага VIII их хурлаас заасан марксист-ленинист гадаад, дотоод бодлогын замд эргэж орохоос зайлсхийж байгааг харуулж байна.

ХКН-ын өнөөгийн эрх баригчид ХКН ба хятадын ард түмний ирээдүйн хувь заяанд хэрхэн хандаж байгаа нь бээжингийнхний мөрийн хөтөлбөр болгон зарлаж байгаа дээрх баримт бичгээс дараахи хэдэн асуудлаар үнэлэлт дүгнэлт хийж болмоор байна.

**Нийгэм-эдийн засгийн талаар:** ХКН-ын VIII их хурлын түүхт шийдвэрээс урван тэрсэлснээс хойших 20 гаруй жилийн хугацаанд хятадын нийгэм-эдийн засгийн дэвшил хөгжилд нааштай сайн өөрчлөлт огтхон ч гарсангүй. «Дорнодын салхи Өрнөдийн салхийг үлээнэ» гэсэн Мао Зедуны заалтын үүднээс социализмын нийгэм-эдийн засгийн онолыг дайран довтолж «их үсрэлт», «соёлын хувьсгал» гэгчдийн үр дагавараар бий болсон «хуарангийн социализм»-ын туршилт Хятад орноор барахгүй Кампучид Пол Пот-Иенг Сари-хны цуст дэглэмийн сүйрлээр балран унасан билээ.

Мао Зедуны хойчийг залгамжлагчдын нийгэм-эдийн засгийн бодлогын үндсэн чиглэл «дөрвөн шинэчлэлт»-ийн онолыг боловсруулсан хятадын ШУА-ийн ерөнхийлөгч Ху Цяому эдийн засгийг удирдах капиталистуудын аргыг эзэмшиж чадвал Хятад улс «дөрвөн шинэчлэлт»-ийг хэрэгжүүлж чадна гэж үзжээ. Иймээс ч ЕЭЗН-ийн төлөөлөгчид бээжингийнхний бодлогыг шалмаг тусган авч, Өрнөд Герман 12 млрд, Франц 10 млрд, Английн банкнууд 1,2 млрд долларын зээл олгох хувиар гаргажээ. Америкийн мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар Хятад 1985 он гэхэд Өрнөдийнхнөөс 30-33 миллиард долларын зээл<sup>5</sup> авна гэж үзэж байна. Хятадын нийгмийг цэрэгжүүлэхэд чиглэсэн «дөрвөн шинэчлэлт»-ийн бодлого нь социалист байгуулалтын марксист-ленинист эдийн засгийн онолыг капиталист орнуудаас «зөөвөрлөн авах туршлагаар» засварлах гэсэн бээжингийнхний оролдлого «Өрнөдийн салхи»-ны аясаар жолоодогдож яваа нь илэрхий юм.

Тэгвэл, ЗХУ, социалист бусад орон, олон улсын коммунист, ажилчны намууд, жинхэнэ марксист-ленинист коммунистууд хятадын нийгэм-эдийн засгийн социалист хөгжилтийн цаашдын төлөвийг байнга сэтгэл

<sup>4</sup>«Улаан туг» Бээжин, № 13, 1981. 16 дугаар талд. (монголоор)

<sup>5</sup>Владимир Глебов. Трагедия без антрактов. АПН. М., 1980. стр 43

зовон ширтэн харж байдаг билээ. Энэ асуудлаар Баруун Германы коммунист намын гишүүн, хятад судлаач Юрген Ройш\* «Хятад социалист хэвээр байна уу?» гэсэн асуудал тавиад: «Маоизм бол гадаад бодлогоороо империализмын бүх дэлхийн стратегтэй бүрэн сүлбэлдсэн их гүрний үндсэрхэх дээрэнгүй үзэл, дайн өдөөгч үзэл, маоизм-энхийг эрхэмлэгч социалист хөршийнхөө эсрэг түрэмгийлэгч бодлого, хүний материаллаг болон соёлын наад захын ч хэрэгцээг хангах чадваргүй»<sup>6</sup> гэж тэмдэглээд, ийм нөхцөлд хэдийгээр хятадын үндэсний онцлогийг харгалзан үзлээ ч гэсэн социализм байгуулах боломжгүй гэсэн дүгнэлт хийжээ.

**Улс төр, үзэл суртлын талаар:** Сүүлийн 20 гаруй жил марксизм-ленинизм, социализмын эсрэг бээжингийнхний баримталж ирсэн улс төр, үзэл суртлын түрэмгий бодлогыг ЗХУКН, ах дүү коммунист, ажилчны бусад нам зарчимчаар шүүмжлэн илчилж, энэ нь БНХАУ дахь социалист байгуулалтанд ямар хор хөнөөл учруулж болохыг урьдчилан сануулсаар ирсэн билээ. «Их үсрэлт», «Соёлын хувьсгал»-ын үед Мао Зэдун, түүний бүлгийнхэн улс төр, үзэл суртлын талаар зарчимгүй дур зоргоороо авирлан, хятадын биш юм бүхнийг үзэн ядаж байсан үндсэрхэх их гүрний дээрэнгүй үзлийн хор нөлөөг арилгах явдал хятадын нийгмийн өмнө зүй ёсоор шаардагдаж байгаа юм. Хятадын эрх баригчдаас 1981 онд Төв Хорооны VI бүгд хурлаар баталсан баримт бичгийн «Соёлын хувьсгалын арван жил», «Мао Зэдуны түүхэн байр ба Мао Зэдуны үзэл санаа» гэсэн хэсгүүдэд «соёлын хувьсгал» нам, улс орон ба ард түмэнд хүнд хохирол учруулсан нугалаа мөнийг нэг талаар хүлээн зөвшөөрсөн атлаа нөгөө талаар «соёлын хувьсгал»-ын уршгаар бий болсон бүх уналтыг Линь Бяо, Зян Цин нар, тэдний талынхан руу чихэж, харин гол буруутан гэмт хэрэгтэн Мао Зэдуныг цагаатган, «Мао Зэдуны үзэл санаа» гэгчийг хятадын «нам, төрийн бодлогын баримтлах мөрийн хөтөлбөр»<sup>7</sup> гэж зарласан байна.

Хятадын одоогийн удирдагчид маоизмыг цаашид ч өвлөн хадгалахыг эрхэмлэн, үндсэрхэх их гүрний дээрэнгүй үзлийг дэвэргэхдээ: «Тус зууны хориод оны сүүлч ба гучаад оны эхээр марксизмыг хоосон номлол болгон, Коминтерний шийдвэр, ЗХУ-ын туршлагыг талархах буруу хэлбэрэл олон улсын коммунист хөдөлгөөн ба манай намын дотор ихээр дэлгэрч, хятадын хувьсгалыг бараг мухардалд оруулжээ»<sup>8</sup> гэсэн марксизм-ленинизмын эсрэг, зөвлөлтийн эсрэг дүгнэлт хийгээд Мао Зэдуны үзэл санаа дээрх «буруу хэлбэрэл»-тэй тэмцэн алхам алхмаар «хөгжин» хятадын хувьсгалын үзэл суртлын систем болсон гэж өргөмжилсөн байна.

Эдгээр баримт нь ХКН-ын VIII их хурлаас улс төр, үзэл суртлын талаар баримтлах үндсэн зарчмыг марксизм-ленинизмын сургаалаар жолоодон, намын улс төр үзэл суртлын ажлын хэмжээг дээшлүүлж байхаар тогтоосон заалтаас хол хөндий хэвээрээ байгааг гэрчилж байна.

**Гадаад бодлогын талаар:** Бээжингийн суртал нэвтрүүлэг ЗХУ ба социалист бусад орны интернационалч гадаад бодлогын мөн чанарыг мушгин гуйвуулж дайран давшилсаар байна. Бээжингийн одоогийн эрх баригчид Өрнөдийн империалист гүрнүүдтэй бүх талаар сүлбэлдэн ойртож, Дэн Сяопин яаравчлан АНУ-д доншуучилсан, БНСВУ-д түрэм-

\*Юрген Ройш марксист нийтлэгч хятад судлаачийн хувьд: «Maoismus in der Krise» Frankfurt (Main 1975 «Ist China noch sozialistisch?» Frankfurt) Main. 1980. зэрэг номууд, мөн «Die nationale frage in der BRD heute und die Politik der Pekinger Fuhrer» гэх мэт олон өгүүлэл нийтлүүлсэн юм.

<sup>6</sup>Jurgen R. Ist China Noch sozialistisch? Frankfurt/Main 1980. S 147.

<sup>7</sup>«Улаан туг» Бээжин, 1981. № 13, 23 дугаар талд. (монголоор)

<sup>8</sup>«Улаан туг» Бээжин, № 13, 1981. 37 дугаар талд. (монголоор)

гйлэн дайрсан зэрэг нь бие биеэ дайсагнасан улс төрийн бүлэглэлүүдийн зарим толгойлогчийн дургүйцлийг хүргэжээ. Гэвч тэднийг нэгтгэж байгаа ганц зүйл нь зөвлөлтийн эсрэг, ЗХУ-ыг дайснагнагч үзэл, «Зөвлөлтийн аюул» гэгч хоосон суртал нэвтрүүлгээр бусад улс орныг далайлгахад оршиж байна. Дэн Сяопин АНУ, Өрнөд Европ болон Японыг оролцуулсан «Өргөн фронтыг» Хятадтай нэгдэн байгуулахыг уриалж байна. Энэ бол ХКН-ын VIII их хурлаас заасан ЗХУ ба социалист бусад оронтой тогтоосон найрамдлыг бэхжүүлж байх гадаад бодлогыг таягдан хаясныг харуулж байна.

Энэ онд хуралдсан ХКН-ын Төв Хорооны VI бүгд хурлын шийдвэрт БНХАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг сэргээн босгоход болон анхдугаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхэд ЗХУ ба социалист бусад орноос өөр хэнээс ч авч чадахгүй байсан асар их тусламж, түүний дотор зөвхөн ЗХУ-ын хөрөнгө, техник, төхөөрөмжөөр барьж ашиглалтанд оруулсан 135 аж үйлдвэрийн газар,<sup>9</sup> зэргийн тухай огт дурдаагүй атлаа «их үсрэлт»-ийн бодлогын уршгаар сүйрсэн эдийн засгийн уналт,<sup>10</sup> мөн «соёлын хувьсгал»-ын гайгаар самуурсан улс төр, үзэл суртлын замбараагүй байдал<sup>11</sup> зэргийг ЗХУ-ын буруугаас болсон мэтээр номлосон байна.

Зөвлөлтийн эсрэг бээжингийнхний улангассан суртал нэвтрүүлэг нь улс орныхоо дотоодод үндсэрхэх их гүрний дээрэнгүй үзлийг дэвэргэх, гадаадад ЗХУ-ын гадаад бодлогын энх тайванч мөн чанарыг мушгин гуйвуулж гүтгэн гүжирдэх гол зорилго агуулж байна.

Бээжингийн одоогийн эрх баригчид гадаад бодлогынхоо зарим хэсгийг томъёолохдоо «пролетарийн интернационализмын зарчимд үнэнч байна», «империализмын эсрэг шийдвэртэй тэмцэнэ»<sup>12</sup> гэсэн үг өгүүлбэрийг ч оруулж, хятадын ард түмэн дэлхийн олон нийтийн санааг хууран мэхлэж төөрөлдүүлэхийг эрмэлзэж байна. Иймэрхүү халхавчийн цаана бээжингийн эрх баригчид улс түмний энх тайван, аюулгүй байдлын дайсан болохыг бодит олон баримт нотлон харуулж байгаа билээ. Бээжингийнхэн л 1962 онд Энэтхэгт, 1979 онд БНСВУ-д халдан довтолсон бөгөөд Алс Дорнодод байдлыг хурцатгасан өдий төдий өдөөн хатгалга дэгдээж, хөрш зэргэлдээ орнууд ЗСБНХУ, БНМАУ, БНАЛАУ, БНСВУ болон Бирм зэрэг орны хил дээр удаа дараа зэвсэгт мөргөлдөөн гарган түгшүүртэй байдал бий болгож байсныг дэлхийн олон нийт сайн мэднэ. Энэ бүхэн нь бээжингийн өнөөгийн эрх баригчид гадаад бодлогынхоо талаар мөн л маоизмын хуучин замналаар олон улсын байдлыг улам хурцатгах, зөвлөлтийг болон социалист бусад орныг ил далдаар дайсагнан, империалист гүрнүүдтэй эвсэлдэн хуйвалдах замаар их гүрний жанжлах, түрэмгийлэн эзлэх дээрэнгүй бодлогоо хэрэгжүүлэхийг зорьсоор байгааг гэрчилж байна.

х хх

Бээжингийн өнөөгийн эрх баригчдын баримталж байгаа дотоод, гадаад бодлогын онол-үзэл суртлын үндэс болсон маоизмын мөн чанарыг Хятадын Коммунист Намын нэрт зүтгэлтэн Ван Мин дүгнэхдээ: «Хятадын болон даян дэлхийн өмнө зэсээ цухуйлгасан Мао Зэдуны үзэл санаа Мао Зэдуны нэгэн адил алдаа завхрал, худал хуурамчийн шинж тэмдэг, гачигдал зүдгүүр, гай зовлонгийн шинж тэмдэг, хэрцгий бал-

<sup>9</sup>О. Б. Борисов, Б. Т. Колосков. «Зөвлөлт-Хятадын харилцаа», М., 1979. 142 дугаар талд (монголоор)

<sup>10</sup>«Улаан туг», Бээжин. № 13. 20—21 ба 30 дугаар талд (монголоор)

<sup>11</sup>Мөн тэнд

<sup>12</sup>«Улаан туг» Бээжин. № 13, 1981. 51 дүгээр талд (монголоор)

мад, зэрлэг танхайгийн шинж тэмдэг, тэнэг мунхаг, хувьсгалын эсэргүү явдлын шинж тэмдэг болсон юм»<sup>13</sup> гэсэн билээ.

1981 онд хуралдсан ХКН-ын Төв Хорооны VI бүгд хурлын шийдвэр нь маоизмын үзэл суртал, улс төрийн хямралыг дахин харуулж, ХКН ба улс орны эрх баригч улс төрийн бүлэглэлүүдийн хоорондын тэмцлийн зөвхөн түр зуурын зохицуулалт болов. Тус бүгд хурал ХКН ба улс орны нийгмийн хөгжлийн цаашдын төлөвийн талаар шинжлэх ухааны мөрийн хөтөлбөр болж чадах шийдвэр гаргасангүй. Энэ бүхэн нь олон улсын интернационалч коммунист, ажилчны намууд, 1980-1981 онд хуралдсан ах дүү социалист орнуудын коммунист ажилчны намууд, ялангуяа ЗХУКН-ын XXVI их хурлаас Хятад дахь хэрэг явдалд өгсөн удаа дараагийн үнэлэлт дүгнэлт үнэн зөв болохыг улам бүр нотолж байна.

## О VIII СЪЕЗДЕ КПК (к 25-летию)

### (Резюме)

**Ч. Бямба**

Статья посвящена 25-летию VIII съезда КПК. Съездом была принята генеральная линия партии в переходный период строительства основ социализма в Китае (1953-1967 гг.). Съезд ознаменовался победой подлинно марксистских, интернационалистических сил в партии. В принятых решениях съезда указывалось на: во-первых, постепенное проведение социалистических реформ в городе и деревне; во-вторых, постепенное повышение жизненного уровня рабочих и крестьян, строгое соблюдение социалистического принципа оплаты по труду; в-третьих, съезд пересмотрел некоторые положения устава партии, утвержденного предыдущим съездом, в частности, идейно-политической основой партии был признан марксизм-ленинизм, и было исключено из устава положение о идеях Мао Цзэдуна; в-четвертых, сделан упор на необходимость расширения и углубления сотрудничества с социалистическими странами, и в первую очередь с Советским Союзом.

Однако сразу после окончания съезда маоистская группировка начинает делать все, чтобы помешать выполнению решений VIII съезда. Мао Цзэдун выдвигает и проводит в жизнь авантюристическую платформу, нашедшую свое выражение в «десяти великих взаимоотношениях», в «трех красных знаменах» и террористической кампании «культурной революции». Маоистский курс, направленный против решений VIII съезда КПК, причинил непоправимый ущерб всей экономической, политической и культурной жизни страны.

Нынешнее пекинское руководство продолжает маоистскую великоханьско-шовинистическую линию, основанную на антисоциализме и антисоветизме. Это отчетливо прослеживается в «Решениях по некоторым вопросам истории КПК со времени образования КНР», принятых на VI Пленуме КПК в июле 1981 года. Как в «Решениях», так и в речи председателя ЦК КПК Ху Яобаня на собрании, посвященном 60-летию КПК,

<sup>13</sup>Ван мин «Ленин, ленинизм и китайская революция» М., 1970, стр 24.

ни слова не упоминается об исторической значимости VIII съезда партии.

Однако сколько бы ни старалось нынешнее пекинское руководство умалить значение VIII съезда КПК и замалчивать о его интернационалистической внешнеполитической линии, этот съезд навсегда останется памятным не только для коммунистов-интернационалистов и многомиллионных трудящихся Китая, но и для всех честных борцов за мир, демократию, социализм и национальное освобождение.